



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/09

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “ТЭМҮҮЛЭЛ” хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (Э.Жигжид)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Э.Цэрэннадмид), Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

